



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 6 сарын 20 өдөр

Дугаар 182


Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их, сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төрболд овогтой Бат-Оргилыг АНУ-ын Колумбын Их сургуулийн магистрантурт эдийн засгийн бодлогын удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Доржсүрэн овогтой Ундармааг АНУ-ын Пейс Их сургуулийн магистрантурт байгаль орчны эрх зүйн чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Шийлэгдамба овогтой Энхтүвшинг АНУ-ын Калифорнийн Их сургуулийн магистрантурт мал эмнэл зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Эрдэнэ овогтой Батбилэгийг Австрали улсын "РМИТ" Их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Сэнхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



[Handwritten signature]
А.ЦАНЖИД